



**“БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТ ТӨСЛИЙН НЭГЖ” ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ТӨСӨВТ
ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ДУНД ХУГАЦААНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ**

(2023-2024 он)



**Улаанбаатар хот
2023 он**

АГУУЛГА

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

ХОЁР. МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ

ГУРАВ. БАЙГУУЛЛАГЫН АЛСЫН ХАРАА

ДӨРӨВ. ЭРХЭМ ЗОРИЛГО

ТАВ. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

ЗУРГАА. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ

ДОЛОО. СТРАТЕГИЙН ЗОРИЛГЫГ ХЭМЖИХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, СУУРЬ БОЛОН
ЗОРИЛТОТ ТҮВШИН, СТРАТЕГИ

НАЙМ. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО БА САЛБАР, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ,
БАЙГУУЛЛАГЫН БҮТЦИЙН УЯЛДАА, ЗУРАГЛАЛ

ЕС. ХАВСРАЛТ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 53-р зүйлийн 53.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1.3 дах заалт, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1.3.1 дэх заалтын хэрэгжилтийг хангах зорилгоор Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын “Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын дэд системийг ашиглалтанд оруулахаар ажиллаж байгаа болон Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор баталсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”-ын дагуу “Бэлчээрийн менежмент төслийн нэгж”–ОНӨТҮГ-ын 2023-2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулав.

“Бэлчээрийн менежмент төслийн нэгж”–ОНӨТҮГ-аас баримтлах алсын хараа, эрхэм зорилго, стратегийн зорилго, зорилт, үйл ажиллагааны цөм нь өндөр хөгжилтэй орнуудын бэлчээрийн менежментийг сайжруулах талаар хөгжүүлсэн арга туршлагаас өөрийн үйл ажиллагаанд үр ашигтай туршин нэвтрүүлсэн ажлын сайн үр дүнд тулгуурлан бэлчээрийн талхагдлыг бууруулах, хөрсийг нь хамгаалах сайжруулах, шинэ төрлийн ногоон тэжээл үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх ажлыг үргэлжлүүлэн хийхэд оршино. Үүнд:

Нийслэл орчмын бэлчээрийн талхагдлыг бууруулах, хөрс хамгаалах, сайжруулах талаар олон улсын тэргүүний технологи, ажлын туршлагыг үйлдвэрлэлд нэвтрүүлж, шинэ төрлийн ногоон тэжээл үйлдвэрлэх ажлыг эрчимжүүлж, саалийн хугацаанд авах сүүний гарцыг нэмэгдүүлснээр нийслэлийн хүн амын сүүний хэрэгцээг дотоодын бүтээгдэхүүнээр хангах, хөдөө аж ахуйн зориулалттай газрын ашиглалтыг сайжруулах, "АЛСЫН ХАРАА-2050" ЗУРГАА. НОГООН ХӨГЖИЛ: 6.2.7 дахь хэсэгт заасан “Хөрсний үржил шим чийгийг хамгаалж, газрын доройтол цөлжилтөөс сэргийлэх” бодлогын зорилтыг биелүүлэхэд хувь нэмэр оруулна.

Мөн 2021 онд батлагдсан Нийслэлийн 2021-2024 оны стратеги төлөвлөгөөний Ерөнхий чиг үүрэг 6-д заасан Хүнсний аюулгүй байдлыг хангаж, хөдөө аж ахуйг хөгжүүлэх заалтын 6.4 дэх хэсэг: Мал аж ахуйг хөгжүүлэх бодлого боловсруулж хэрэгжүүлэх хэсэгт манай байгууллагатай холбоотой дараах 2 гол үндсэн ажил үүрэг орсон байна.

1. Бэлчээрийн менежмент
2. Малын тэжээлийн нөөц бүрдүүлэлт

Үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөг хэрэгжүүлснээр нийслэлийн хэмжээнд эрчимжсэн мал аж ахуйн загвар ферм, сургалтын төв болон хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмж бүхий Техник дундын үйлчилгээний төв бий болж, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжүүдэд орчин үеийн дэвшилтэт шинэ техник, технологи

танилцуулах, иргэд, байгууллага, аж ахуйн нэгжийн захиалгын дагуу хөдөө аж ахуйн үйлчилгээг хямд үнээр чанарын өндөр түвшинд гүйцэтгэх боломж бүрдэх болно.

Төлөвлөгөө боловсруулахад баримталсан зарчим

1. Стратеги төлөвлөгөөнд тусгасан зорилтын хүрээнд хүлээгдэж байгаа өөрчлөлтийг илэрхийлсэн тодорхой зорилт, арга хэмжээг агуулсан байх бөгөөд тэдгээр нь хоорондоо уялдсан байх.
2. Төлөвлөгөөнд зорилт арга хэмжээг хэрэгжүүлснээр бий болох үр дүн, түүнийг хэмжих шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон байх.
3. Шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшин нь тухайн жилдээ хэрэгжих боломжтой, тоон болон чанарын утгаар илэрхийлэгдэх, хэмжигдэхүйц үр дүнг харуулсан байх бөгөөд бодлогын баримт бичиг, статистик тоон мэдээлэл салбарын мэдээлэлд үндэслэх, арга хэмжээний хүрэх түвшин нь зорилтын үр дүнг илэрхийлсэн байх.

Төлөвлөгөөний хамрах хүрээ, хугацаа:

“Бэлчээрийн менежмент” төслийн нэгж ОНӨТҮГ-нь Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн 2021-2024 оны стратеги төлөвлөгөөний тус байгууллагад хамрааралтай төлөөлөн гүйцэтгүүлэх чиг үүрэг болон эдийн засаг, нийгмийн хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх, нийслэл орчмын бэлчээрийн менежментийг сайжруулах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгыг нийслэлийн хэмжээнд 2023-2024 онд хэрэгжүүлэхээр тодорхойлов.

**ХОЁР. “БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТ ТӨСЛИЙН НЭГЖ” – ОНӨТҮГ-ЫН
МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ**

“Бэлчээрийн менежмент төслийн нэгж” ОНӨТҮГ-ын мандатыг тодорхойлохдоо Монгол Улсын хууль тогтоомж, эрх зүйн актаар тус байгууллагад хуулиар олгосон чиг үүргийг хамруулж тодорхойлсон. Үүнд:

Салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хуулийн тоо		37
Үүнээс:	Тухайн салбарын хуулийн тоо	12
	Нийтлэг мөрддөг хуулийн тоо	26
Ерөнхий чиг үүрэг-1: Нийслэл орчмын бэлчээрийн менежментийг сайжруулах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлж, БНАУ-ын дэвшилтэт технологийн дагуу бэлчээрийн талбайн хөрсний бүтцийг алдагдуулахгүйгээр өөрийн орны хөрс цаг уурын нөхцөлд тохируулан, байгаль орчинд ээлтэй, олон наст ногоон тэжээлийг тарималжуулан нутагшуулах замаар тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, бэлчээр ашиглалтыг сайжруулах ажлыг зохион байгуулах.		
Үндсэн чиг үүрэг		Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид

ҮЧҮ-1.1 БНАУ-н шилдэг технологийг нутагшуулах замаар нэгж талбайгаас хураан авах ургацын хэмжээг нэмэгдүүлж, чанарыг сайжруулах	Бэлчээрийн талбайг хагалахгүй, хөрсний унаган төрхийг алдагдуулахгүйгээр үрлэж тариалах, N,P,K-бордоо болон малын өтөг бууц, шивхээр бордох зэрэг БНАУ-ын дэвшилтэт технологийг туршиж, нэвтрүүлэх	ХХААХҮЯ, НЗДТГ, НХХААГ, НБОГ, СХД, тухайн чиглэлийн ТББ, ОУБ, Их дээд сургууль, Эрдэм шинжилгээний байгууллага, иргэд, ААН
	Дээрх технологийн дагуу тариалсан олон найрлагат, уурагт ногоон тэжээлийг вакумжуулан боох аргыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх	
	Туршилтын талбайн ургамлын бүтэц бүрдлийг нэмж, хөрсийг бордож сайжруулах замаар нэгж талбайгаас авах хадлангийн гарцыг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлэх	
	Нэгж талбайгаас авах хадлангийн хэмжээ болон ногоон тэжээлийн чанарыг сайжруулснаар саалийн хугацаанд нэг үнээнээс авах сүүний хэмжээг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлэх	
Ерөнхий чиг үүрэг-2: Сургалтын төв, дадлагын талбай болон засварын төв бүхий Эрчимжсэн мал аж ахуйн загвар аж ахуй байгуулах.		
Үндсэн чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
ҮЧҮ-2.1 Малчид фермерүүдийн дундын хоршоо байгуулах замаар дээрх дэвшилтэт технологийг малчид фермерүүдийн талбай дээр нэвтрүүлэх	Нийслэл орчмын бэлчээрийн менежментийг сайжруулахад малчид, фермерүүдэд сургалт арга зүйн зөвлөгөө өгөх	ХХААХҮЯ, НЗДТГ, НХХААГ, НБОГ, СХД, тухайн чиглэлийн ТББ, ОУБ, Их дээд сургууль, Эрдэм шинжилгээний байгууллага, иргэд, ААН
	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор иргэдэд хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмжөөр үйлчилгээ үзүүлэх	
	Монгол улсын цаг уур, хөрсөнд тохирсон шим тэжээлт олон наст үрийн холимгийг Австри Улсын үрийн холимогт тулгуурлан туршилт, судалгаа хийж гаргаж авах.	
Ерөнхий чиг үүрэг-3: Байгууллагын дотоод үйл ажиллагааны хяналтыг сайжруулах, хүний нөөцийг төлөвлөх хэрэгжүүлэх, төсөв, хөрөнгө оруулалт, урсгал зардлын төсвийн төлөвлөлт, хэрэгжилт, ил тод байдлыг хангаж ажиллах		
Үндсэн чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
ҮЧҮ-.1 Байгууллагын чиг үүрэгтэй холбоотой гарсан тогтоол шийдвэрийн биелэлтийг хангуулж, тайлагнах, дотоод үйл ажиллагааны хяналт шалгалт, үйл ажиллагааг сайжруулах	Байгууллагын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлан, санхүүгийн төлөвлөгөө тайлагнал хяналтыг сайжруулах	НЗДТГ, НАГ, НХХААГ, ХХААХҮЯ
	Нийслэлийн дотоод удирдлагын нэгдсэн системийг бүрэн ашиглаж, хэрэгжилтийг хангах	
Ерөнхий чиг үүрэг-4: Байгууллагын Хүний нөөцийн чадавхийг хөгжүүлэх. нийгмийн баталгааг хангах		

Үндсэн чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
ҮЧҮ-3.1 Ажилтан, албан хаагчдын мэдлэг, мэргэжлийн ур чадварыг тасралтгүй сайжруулж, байгууллагын хүний нөөцийн чадавхийг хөгжүүлэх	Ажилтан, албан хаагчдыг мэдлэг, мэргэжлийн ур чадвар дээшлүүлэх гадаад, дотоодын сургалтад хамруулж, хүний нөөцийн хүртээмжтэй байдлыг ханган ажиллах	НЗДТГ, хамтрагч байгууллагууд
ҮЧҮ-3.2 Нийт албан хаагчдыг идэвхжүүлэх, урамшуулах	Ажлын үр дүнгээр олгосон нэмэгдэл хөлс, урамшуулал, шагналыг хууль, журмын дагуу олгох	НЗДТГ, хамтрагч байгууллагууд
ҮЧҮ-3.3 Нийт албан хаагчдын эрүүл мэндийг дэмжих, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх	Ажилтан, албан хаагчдыг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгт хамруулж, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх	УНТЭ, бусад эмнэлэг

ГУРАВ. “БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТ ТӨСЛИЙН НЭГЖ” – ОНӨТҮГ-ЫН АЛСЫН ХАРАА (VISION)

Нийслэлийн хэмжээнд бэлчээрийн менежментийг сайжруулах чиглэлээр нэвтрүүлж буй орчин үеийн дэвшилтэт техник, технологийг нутагшуулах болон иргэд, аж ахуйн нэгжид техникийн үйлчилгээ үзүүлэх зорилго бүхий жишиг төв болно.

ДӨРӨВ. ЭРХЭМ ЗОРИЛГО (MISSION)

Нийслэл орчмын бэлчээрийн менежментийг сайжруулан, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, шинэ төрлийн ногоон тэжээлийн үйлдвэрлэлийг нэвтрүүлсний үр дүнд саалийн хугацаанд авах сүүний гарцыг нэмэгдүүлж, нийслэлийн хүн амыг эрүүл, аюулгүй сүү, сүүн бүтээгдэхүүнээр хангах ажилд бодит хувь нэмэр оруулна.

ТАВ. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

Орчны шинжилгээг удирдлагыг стратегийн шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллээр хангах зорилгоор хийнэ. Салбар болон засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага, байгууллага нь бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, хуулиар ногдуулсан чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн зорилтыг хэрэгжүүлэх боломж ямар байгааг гадаад ба дотоод орчны хүчин зүйлийн хүрээнд тулгуурлан бодитойгоор тодорхойлно.

Гадаад орчны шинжилгээг хийхдээ улс төр, эдийн засаг, нийгэм соёл, технологи, хууль эрх зүй, байгаль орчны зүгээс үзүүлэх нөлөөллийг тодорхойлсноор ямар эерэг боломж, ямар сөрөг нөлөөлөл, эрсдэл байгааг гаргана.

Дотоод орчны шинжилгээг хийхдээ салбар болон засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, байгууллагын бүтэц, зохион байгуулалт, соёл, нөөц (хүн, санхүү, техник, мэдээлэл) хийгээд технологийн үйл явц зэрэг хүчин зүйлсийн хүрээнд давуу ба сул талыг тодорхойлно.

Гадаад ба дотоод орчны зүгээс нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлсны үндсэн дээр орчны шинжилгээний үр дүнг CBOT (Strengths, Weaknesses, Opportunities, Threats) хүснэгтэд нэгтгэн харуулна.

Орчны (SWOT) шинжилгээг нэгтгэх хүснэгт

Бүрэлдэхүүн хэсгүүд	Давуу тал /Strengths/	Сул тал /Weaknesses
ДОТООД ОРЧИН	- Хүлээсэн чиг үүрэг, батлагдсан бодлого, хөтөлбөртэй. - Эрхлэх асуудлын хүрээнд бие даасан бүтэц, зохион байгуулалттай. - Ажиллах орчин нөхцөл, компьютер, тоног төхөөрөмжийн хангалт сайн бүрдсэн. - Мэргэжлийн боловсон хүчний хангалт сайн - Гадаад, дотоодын байгууллагуудтай хамтын ажиллагаатай. - Дотоод албан хэрэг хөтлөлтийн программ нэвтэрсэн.	- Төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа, уялдаа холбоо сул - Гадаад харилцаа, хамтын ажиллагаа хангалтгүй - Албан хаагчдын нийгмийн баталгаа хангалтгүй - Төсвийн санхүүжилтэд байх ёстой урсгал зардлууд тусгагдаагүй. - Ажиллах нөхцөл, цалин хөлсний хэмжээнээс шалтгаалж мэргэжлийн боловсон хүчин тогтворгүй, бүрэн хангагдаагүй. - Үндсэн зорилтыг хэрэгжүүлэхэд хүчин чадлаараа ажиллаж эхлэхэд шаардагдах нарийн мэргэжлийн боловсон хүчнээр бүрэн хангагдаагүй. - Байгууллагын үйл ажиллагааны статус нэг мөр тодорхой шийдвэрлэгдээгүй
ГАДААД ОРЧИН	<u>Боломж /Opportunities/</u> "АЛСЫН ХАРАА-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын ЗУРГАА. НОГООН ХӨГЖИЛ: 6.2.7-д <u>Хөрсний үржил шим чийгийг хамгаалж, газрын доройтол цөлжилтөөс сэргийлэх</u> гэсэн байгууллагын үндсэн чиг үүрэгт хамааралтай заалт тусгагдсан. - Төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, гадаад хамтын ажиллагаа сайжруулах замаар дэвшилтэт техник, технологийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, - Эрдэм шинжилгээний бусад байгууллагуудтай хамтран ажилладаг.	<u>Бэрхшээл /Threats/</u> - Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт дутмаг - Санхүү, эдийн засгийн хүндрэлээс шалтгаалж, хөтөлбөрийн хэрэгжилт хангалтгүй - Малчдын хоршоо байгуулах болон бэлчээрийн талхагдлыг хэрхэн бууруулах талаар малчид, фермерүүдийн мэдлэг муу. - Иргэн, аж ахуйн нэгжид бэлчээрийг зохистой ашиглах талаар шалгалт хийх, хариуцлага тооцох эрхзүйн орчин бүрдээгүй. - Туршилтын талбайд технологийн дагуу усалгаа хийх боломж муу, байнгын услалтын систем байхгүй, тул байгалын хур тундасаас хэт их хамааралтай

	• Шинэ санаа, бүтээлч үйл ажиллагааг идэвхжүүлэх боломж нөхцлөөр хангагдсан. • Ажлын байр нэмэгдэж, иргэд, Аж ахуй нэгж, малчид фермерүүдийг сургалтанд хамруулах боломж бүрдэнэ. • Уурагт ногоон тэжээлийн хангамж нэмэгдэнэ. • Фермерүүд тэжээлийн зардлыг бууруулж, эдийн засгийн хувьд ашигтай ажиллах боломжтой.	
--	--	--

Орчны (SWOT) шинжилгээний дүгнэлт:

Манай байгууллага нийслэл орчмын бэлчээрийн менежментийг сайжруулж, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх замаар нийслэлийн хүн амын сүүний хангамжийг сайжруулах, газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчидэд чанар сайтай техникийн үйлчилгээ үзүүлэх зорилго тавин ажилладаг. Тус байгууллагын албан хаагчдаас түүвэрлэн авсан саналд гадаад, дотоод орчинд SWOT шинжилгээ хийж үзэхэд төсөл хэрэгжүүлэх гадаадын болон дотоодын мэргэжлийн боловсон хүчин, тоног төхөөрөмжийн хангамж сайн, ойр хавийн малчид, фермерүүдэд сургалт явуулж, зөвлөгөө өгөхөд боломж бүрдсэн зэрэг нь давуу тал болж байна.

Мөн Австри улсын хөдөө аж ахуйн салбарт хэрэгжүүлсэн НОУ-ХАУ-г монголын нөхцөлд нутагшуулах ажил амжилттай хэрэгжиж, хамтын ажиллагаа түлхүү хөгжсөн давуу тал байна.

Гадаад орчны тулгарч буй сул талууд :

Байгууллагын хэмжээнд төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд төсөв хөрөнгө дутмаг, нийслэлийн бусад байгууллагатай хамтран ажиллах уялдаа холбоо муу. Мал аж ахуй, газар тариалангийн чиглэлээр хяналт, шалгалт хийх эрх зүйн орчин бүрдээгүй нь төслийг амжилттай хэрэгжүүлэхэд тодорхой хэмжээнд нөлөөлж байна.

Дээрхи шинжилгээний үр дүнд цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах, Санамж бичиг болон хамтын ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, батлуулах
- БНАУ-аас гадна хөдөө аж ахуй, бэлчээрийн менежментийн чиглэлээр өндөр хөгжилтэй бусад орнуудтай хамтран ажиллах, туршлага солилцох, үйл ажиллагаандаа нэвтрүүлэх
- Нийслэлийн төсөвт төсөл хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг суулгах
- Иргэд, олон нийтэд өөрийн байгууллагын үйл ажиллагааг сурталчилах чиглэлээр хэвлэл, мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах
- Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх замаар албан хаагчдын амьдралд дэмжлэг үзүүлэх зэрэг арга хэмжээнүүд болно.

ЗУРГАА. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Стратегийн зорилго-1:

Нийслэл орчмын бэлчээрийн менежментийг сайжруулах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлж, БНАУ-ын дэвшилтэт технологийн дагуу бэлчээрийн талбайн хөрсний бүтцийг алдагдуулахгүйгээр өөрийн орны хөрс цаг уурын нөхцөлд тохируулан, байгаль орчинд ээлтэй, олон наст ногоон тэжээлийг тарималжуулан нутагшуулах замаар тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, бэлчээр ашиглалтыг сайжруулах ажлыг зохион байгуулахад оршино.

Стратегийн зорилт - 1.1.

Эрс тэс уур амьсгалтай, уулархаг бүс нутагт дасан зохицсон, хөрс болон тэжээлийн чанарыг сайжруулах чадвар бүхий Австри улсад үйлдвэрлэсэн “NATRO” олон наст үрийн холимгийг монголын нөхцөлд нутагшуулсны үр дүнд бэлчээрийн талбайн хөрсний үржил шимийг сайжруулан, ногоон тэжээлийн шинэ төрлийг бий болгох.

Стратегийн зорилт-1.2.

Техник дундын үйлчилгээний төвийг байгуулсны үр дүнд чанарын шаардлага хангасан газар тариалангийн үйлчилгээг хямд үнээр иргэн, аж ахуйн нэгжид үзүүлэх.

Стратегийн зорилт-1.3.

Сургалтын төв, туршилтын талбай, үнээний ферм болон засварын төв бүхий Эрчимжсэн мал аж ахуйн загвар аж ахуй байгуулах.

Стратегийн зорилго-2:

Байгууллагын дотоод үйл ажиллагааны хяналтыг сайжруулах, хүний нөөцийг төлөвлөх хэрэгжүүлэх, төсөв, хөрөнгө оруулалт, урсгал зардлын төсвийн төлөвлөлт, хэрэгжилт, ил тод байдлыг хангаж ажиллах.

Стратегийн зорилт-2.1.

Байгууллагын чиг үүрэгтэй холбоотой гарсан тогтоол шийдвэрийн биелэлтийг хангуулж, тайлагнах, дотоод үйл ажиллагааны хяналт шалгалт, үйл ажиллагааг сайжруулах

Стратегийн зорилго-3:

Байгууллагын Хүний нөөцийн чадавхийг хөгжүүлэх, нийгмийн баталгааг хангах

Стратегийн зорилт-3.1.

Ажилтан, албан хаагчдын мэдлэг, мэргэжлийн ур чадварыг тасралтгүй сайжруулж, байгууллагын хүний нөөцийн чадавхийг хөгжүүлэх.

Стратегийн зорилт-3.2.

Нийт албан хаагчдыг идэвхжүүлэх, урамшуулах.

Стратегийн зорилт-3.3.

Нийт албан хаагчдын эрүүл мэндийг дэмжих, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх.

“Бэлчээрийн менежмент төслийн нэгж” – ОНӨТҮГ-ын мандатад тулгуурласан дээрх зорилтууд нь тус байгууллагын эрхэм зорилгыг хэрэгжүүлж, алсын хараанд хүрэхэд чиглэгдэнэ. Байгууллагын ажилтнууд нь үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтлан ажиллана.

Үүнд:

Нийтэч, ил тод, санаачилгатай

Эвсэг, эерэг, ёс зүйтэй

Мэргэшсэн, мэдлэг чадвартай, бүтээлч

Үнэнч, шударга, хариуцлагатай

Тэгш, хүртээмжтэй

- Нийтэч, ил тод, санаачилгатай. Үйл ажиллагаандаа шинжлэх ухааны нотолгоо, үндэслэлтэй хандаж, ажилтан бүр шинэ техник, технологи, инновацийг нэвтрүүлэгч, санаачлагч, суралцагч, бүтээлч байна.
- Эвсэг, эерэг, ёс зүйтэй. Нийгмийн өмнө хүлээсэн төрийн албан хаагчийн үүрэг, хариуцлагаа дээдлэн, ёс зүй, эерэг харилцаа хандлагыг эрхэмлэн, манлайлж ажиллана.
- Мэргэшсэн, мэдлэг чадвартай, бүтээлч. Ажил үүргээ мэргэжлийн түвшинд мэдлэг, чадварт тулгуурлан гүйцэтгэж, үр дүнг эрхэмлэн ажиллана.
- Үнэнч, шударга, хариуцлагатай. Алхам бүрт хууль тогтоомжийг мөрдөж, шударга, ил тод, шуурхай ажиллана.
- Тэгш, хүртээмжтэй. Ялгаварлан гадуурхалтаас ангид байж, тэгш, хүртээмжтэй байдлыг хангаж ажиллана.

**ДОЛОО. “БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТ ТӨСЛИЙН НЭГЖ”-ОНӨТҮГ-ЫН СТРАТЕГИЙН
ЗОРИЛГЫГ ХЭМЖИХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, СУУРЬ БОЛОН ЗОРИЛТОТ ТҮВШИН**

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин, 2020 оны байдлаар (өмнөх онуудтай нийлээд)	2022 оны байдлаар хүрсэн үр дүн буюу хэрэгжилт	Үр дүнгийн үзүүлэлт, хүрэх түвшин	
					2023 он	2024 он
<u>Ерөнхий чиг үүрэг</u> Нийслэл орчмын бэлчээрийн менежментийг сайжруулах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлж, БНАУ-ын дэвшилтэт технологийн дагуу бэлчээрийн талбайн хөрсний бүтцийг алдагдуулахгүйгээр өөрийн орны хөрс цаг уурын нөхцөлд тохируулан, байгаль орчинд ээлтэй, олон наст ногоон тэжээлийг тарималжуулан нутагшуулах замаар тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, бэлчээр ашиглалтыг сайжруулах ажлыг зохион байгуулах.						
1	Бэлчээрийн талбайг хагалахгүй, хөрсний унаган төрхийг алдагдуулахгүйгээр үрлэж тариалах Австри улсын дэвшилтэт шинэ технологийг туршиж, нутагшуулах ажлыг үргэлжлүүлэх	Шинэ технологийн дагуу тариалж, газрын доройтол, цөлжилтөөс хамгаалсан талбайн хэмжээгээр, га	100 га	Бэлчээрийг нөхөн сэргээхэд зориулагдсан манай орны хөрс цаг уурын нөхцөлд тохирсон БНАУ-д үйлдвэрлэсэн, 2 төрлийн 8 зүйл ургамлаас бүрдсэн олон наст тэжээлийн ургамлын “НАТРО” холимог үрээр 2018 оноос хойш нийт туршилтын 150 га талбайн 85 га-д хөрсийг хөндөхгүй шинэ технологиор тариалалтын ажлыг хийж гүйцэтгэсэн. “НАТРО” холимог үрээс эхний хоёр жил 5-6 зүйл ургамал нутагшиж ургасан, 3 дахь жилээс 5 зүйл үетнээс гадна царгас, хошоонгор гэсэн 2 зүйлийн буурцагтан ургамал ургасан.		
2	Дээрхи технологийн дагуу тариалсан олон найрлагат, уурагжуулсан витаминт тэжээлийг вакумжуулан боох аргыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэх, туршилтын болон хөрс боловсруулалт хийж тариалалт хийсэн талбайгаас ногоон тэжээл хураан авах	Хурааж авах ногоон тэжээлийн хэмжээгээр, тн	20 тн	Дөрвөн жилийн хугацаанд “НАТРО” болон Хятад үр тариалсан 65 га талбайгаас нийт 50600 кг/2021 онд 33500 кг/ ургац хураан авч, боож, шинэ төрлийн өвсөн болон ногоон тэжээл бэлтгэсэн. Сүүлийн хоёр жилийн хугацаанд ногоон тэжээл хураан авахад 1 га-ын дундаж ургац 450-550 кг байсан бол 2021 оны байдлаар Натро үрээр бордож тариалалт хийсэн талбайд 2 зүйлийн буурцагтан, 5 зүйлийн үетэн ургамлыг ургуулж, төрөл зүйлийг нэмэгдүүлсний дүнд 1 га-ын дундаж ургацыг 1300 кг-д хүргэсэн. Бусад; талбайн ургацыг 830 кг болгож сайжруулсан. /Хурааж авах цэвэр ургацын хэмжээгээр дунджаар тооцсон/	38 тн	50 тн

3	Нэгж талбайгаас авах ногоон тэжээлийн чанарыг дээшлүүлснээр саалийн хугацаанд нэг үнээнээс авах сүүний хэмжээг нэмэгдүүлэх	Тэжээл өгсөн үнээний сүүний гарцын хэмжээгээр,	1.5 дахин	Саалийн үнээнүүдээс харилцан адилгүй сүүний гарцтай 3-4 үнээг сонгон авч, вакумжуулан боож бэлтгэсэн ногоон тэжээлээр тэжээхэд, сүүний гарц дунджаар 47,5%- 54,3% хүртэл нэмэгдсэн.	1.5-2 дахин	1.5-2 дахин
4	Малын шивх, өтөг бууц ашиглан органик бордоо бэлтгэж туршилтын талбайг бордож хөрсний чанарыг сайжруулах,	Бэлтгэсэн органик бордооны хэмжээ болон нэмж бордсон талбайн хэмжээгээр, тн/га	45 га/500 тн	Туршилтын 150 га талбайн хөрсний агрохимийн бүтцийн шинжилгээг 2-3 жилд нэг удаа хийж, бордох тунг тооцож нийлмэл эрдэс бордоо болон органик бордоогоор талбайг бордсоны үр дүнд ялзмагийн хэмжээ 2,76% -с 3,99% хүртэл нэмэгдүүлсэн. Мөн тариалалт хийсэн олон наст ургамлын ургалтын байдлыг харгалзан 2021 онд 10 га, 2022 онд 10 га талбайг сонгон авч 1 га-д 10 тн нормоор тооцож компост бордоо болон бууцаар бордох ажлыг хийсэн.	10	20
5	Нийслэлийн иргэд, малчид, фермерүүдэд зориулж хөдөө аж ахуй, газар тариалангийн чиглэлээр сургалт зохион байгуулах	Сургалтанд хамрагдах хүний тоогоор	244 хүн	Малчдын хоршоо байгуулах, ногоон тэжээл тариалах, өтөг бууцыг хэрхэн зөв хадгалж хуримтлуулан талбайгаа бордох, бэлчээрийн доройтлоос сэргийлэхэд иргэдийн дэмжлэг оролцоо ямар байвал хамгийн үр дүнтэй байдаг талаар 2021, 2022 онд нийт 92 хүнд сургалт зөвлөгөө өгч ажилласан.	35	50
6	Техник, дундын үйлчилгээний төвийг түшиглэн иргэд, аж ахуйн нэгжид газар тариалангийн үйлчилгээ үзүүлэх	Хамтран ажиллаж үйлчилгээ авсан иргэд, аж ахуй нэгжийн тоогоор	10	СХД-ийн 21-р хороо, Нарийны хэсгийн 4 иргэний захиалгаар 2021 онд нийт 5,5 га талбайд, 2022 онд 1 аж ахуйн нэгжийн захиалгын дагуу 10 га- талбайд газар Мөн Улаанбаатар хотын захирагчийн ажлын албаны захиалгаар модны тарьц суулгац бэлдэх мод үржүүлгийн газар байгуулах ажлын хүрээнд Хужирбуланд 5 га атаршсан талбайг хагалж, хөрс боловсруулах ажил хийв. Мөн Улаанбаатар хотын захирагчийн ажлын албаны захиалгаар модны тарьц суулгац бэлдэх мод үржүүлгийн газар байгуулах ажлын хүрээнд Хужирбуланд 5 га атаршсан талбайг хагалж, хөрс боловсруулах ажлыг хийж гүйцэтгэв.	5	10

СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨГ БАТАЛСАН:

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД
УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧ

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ

..... (Д.СУМЪЯАБАЗАР)

СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:

“БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТ ТӨСЛИЙН НЭГЖ”
ОНӨТҮГ-ЫН ДАРГА

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

..... (Н.УУГАНБАЯР)

2023.03.31

“БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТ ТӨСЛИЙН НЭГЖ” ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ТӨСӨВТ
ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ, (2023-2024 он)

Бодлогын баримт бичигт тусгагдсан болон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт	Стратеги (арга зам)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин, 2020 оны байдлаар (өмнөх онуудтай нийлээд)	Зорилтот түвшин, 2024 он	Санхүүгийн эх үүсвэр (төгрөгөөр)
<u>Ерөнхий чиг үүргийн нэр:</u> Нийслэл орчмын бэлчээрийн менежментийг сайжруулах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх					
<u>Үндсэн чиг үүргийн нэр:</u> Олон наст ногоон тэжээлийг ургамлыг тарималжуулан нутагшуулах замаар тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, бэлчээр ашиглалтыг сайжруулах ажлыг зохион байгуулах.					

Зорилт-1: Эрс тэс уур амьсгалтай, уулархаг бүс нутагт дасан зохицсон, хөрс болон тэжээлийн чанарыг сайжруулах чадвар бүхий Австри улсад үйлдвэрлэсэн “NATRO” олон наст үрийн холимгийг монголын нөхцөлд нутагшуулсны үр дүнд бэлчээрийн талбайн хөрсний үржил шимийг сайжруулан, ногоон тэжээлийн шинэ төрлийг бий болгох.	Арга хэмжээ-1.1. Бэлчээрийн талбайг хагалахгүй, хөрсний унаган төрхийг алдагдуулахгүй үрлэж тариалах Австри улсын дэвшилтэт шинэ технологийг туршиж, нутагшуулах ажлыг үргэлжлүүлэх	Шинэ технологийн дагуу тариалж, газрын доройтол, цөлжилтөөс хамгаалсан талбайн хэмжээгээр, га	100 га		Нийслэлийн төсөв
	Арга хэмжээ-1.2. Дээрхи технологийн дагуу тариалсан олон найрлагат, уурагжуулсан витаминт тэжээлийг вакуумжуулан боох аргыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэх, туршилтын болон хөрс боловсруулалт хийж тариалалт хийсэн талбайгаас ногоон тэжээл хураан авах	Хурааж авах ногоон тэжээлийн хэмжээгээр, тн	20 тн	50 тн	Нийслэлийн төсөв
	Арга хэмжээ-1.3. Нэгж талбайгаас авах ногоон тэжээлийн чанарыг дээшлүүлснээр саалийн хугацаанд нэг үнээнээс авах сүүний хэмжээг нэмэгдүүлэх	Тэжээл өгсөн үнээний сүүний гарцын хэмжээгээр,	1.5 дахин	1.5-2 дахин	Нийслэлийн төсөв
	Арга хэмжээ-1.4. Малын шивх, өтөг бууц ашиглан органик бордоо бэлтгэж туршилтын талбайг бордож хөрсний чанарыг сайжруулах,	Бэлтгэсэн органик бордооны хэмжээ болон нэмж бордсон талбайн хэмжээгээр, тн/га	45 га/500 тн	20 га/200 тн	Нийслэлийн төсөв
Зорилт-2: Техник дундын үйлчилгээний төвийг байгуулсны үр дүнд чанарын шаардлага хангасан газар тариалангийн үйлчилгээг хямд үнээр иргэн, аж ахуйн нэгжид үзүүлэх.	Арга хэмжээ-2.1. Техник, дундын үйлчилгээний төвийг түшиглэн иргэд, аж ахуйн нэгжид газар тариалангийн үйлчилгээ үзүүлэх	Хамтран ажиллаж үйлчилгээ авсан иргэд, аж ахуй нэгжийн тоогоор	10	10	Нийслэлийн төсөв

Зорилт-3: Сургалтын төв, туршилтын талбай, үнээний ферм болон засварын төв бүхий Эрчимжсэн мал аж ахуйн загвар аж ахуй байгуулах.	Арга хэмжээ-3.1. Нийслэлийн иргэд, малчид, фермерүүдэд зориулж хөдөө аж ахуй, газар тариалангийн чиглэлээр сургалт зохион байгуулах	Сургалтанд хамрагдах хүний тоогоор	244 хүн	50	Нийслэлийн төсөв
Ерөнхий чиг үүргийн нэр: Байгууллагын дотоод үйл ажиллагааны хяналтыг сайжруулах, хүний нөөцийг төлөвлөх хэрэгжүүлэх, төсөв, хөрөнгө оруулалт, урсгал зардлын төсвийн төлөвлөлт, хэрэгжилт, ил тод байдлыг хангаж ажиллах					
Үндсэн чиг үүргийн нэр: Байгууллагын чиг үүрэгтэй холбоотой гарсан тогтоол шийдвэрийн биелэлтийг хангуулж, тайлагнах, дотоод үйл ажиллагааны хяналт шалгалт, үйл ажиллагааг сайжруулах					
Зорилт- 4: Байгууллагын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлан, санхүүгийн төлөвлөгөө тайлагнал хяналтыг сайжруулах	Арга хэмжээ-4.1. Байгууллагын төлөвлөгөө тайлан болон дээд газраас ирсэн тогтоол шийдвэрийн биелэлтийг хуулийн дагуу тайлагнаж ажиллах	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувиар	100 %	100 %	Нийслэлийн төсөв
	Арга хэмжээ-4.2. Байгууллагын үйл ажиллагааны зардлыг зориулалтын дагуу зарцуулж, өр авлага үүсгэхгүй, гүйцэтгэлийг хуулийн дагуу тайлагнаж ажиллах.	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувиар	100 %	100 %	Нийслэлийн төсөв
Зорилт- 5: Нийслэлийн дотоод удирдлагын нэгдсэн системийг бүрэн ашиглаж, хэрэгжилтийг хангах	Арга хэмжээ-5.1. erp.ulaanbaatar.mn дэд системийн ашиглалтыг сайжруулж, аливаа баримт бичгийг хуулийн дагуу хугацаанд нь шийдвэрлэхэд анхаарч ажиллах, Archive.edoc программд байгууллагын баримтын бүртгэлийг үүсгэх	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувиар	100 %	100 %	Нийслэлийн төсөв

<u>Ерөнхий чиг үүргийн нэр:</u> Хүний нөөцийн чадавхийг хөгжүүлэх, нийгмийн баталгааг хангах					
<i>Үндсэн чиг үүргийн нэр:</i> Байгууллагын хүний нөөцийн чадавхийг хөгжүүлэх, ажилтан, албан хаагчдын мэдлэг, мэргэжлийн ур чадварыг тасралтгүй сайжруулж, идэвхижүүлэх, урамшуулах,					
Зорилт- 6: Ажилтан, албан хаагчдыг мэдлэг, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх гадаад, дотоодын сургалтад хамруулж, хүний нөөцийн хүртээмжтэй байдлыг хангах, идэвхижүүлэх, урамшуулах	Арга хэмжээ-6.1. Ажилтан, албан хаагчдыг мэдлэг, мэргэжлийн ур чадвар дээшлүүлэх гадаад, дотоодын сургалтад хамруулж, хүний нөөцийн хүртээмжтэй байдлыг ханган ажиллах	Сургалтанд хамрагдсан албан хаагчийн тоогоор	10	10	Нийслэлийн төсөв
	Арга хэмжээ-6.2. Ажлын үр дүнгээр олгосон нэмэгдэл хөлс, урамшуулал, шагналыг хууль, журмын дагуу олгох	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувиар	100 %	100 %	Нийслэлийн төсөв
Зорилт-7: Нийт албан хаагчдын эрүүл мэндийг дэмжих, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх	Арга хэмжээ-7.1. Ажилтан, албан хаагчдыг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгт хамруулж, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх	Үзлэг оношлогоонд хамрагдсан албан хаагчийн тоогоор	10	10	Нийслэлийн төсөв

**НАЙМ. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО БА САЛБАР, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ,
БАЙГУУЛЛАГЫН БҮТЦИЙН УЯЛДАА, ЗУРАГЛАЛ**

“Бэлчээрийн менежмент төслийн нэгж” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар нь “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 оны хөгжлийн чиг хандлагын баримт бичиг”, Нийслэлийн Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.8.1-д заасан Улаанбаатар хотын сүүний хэрэглээний 80 хувийг дотоодын үйлдвэрлэлээр хангах зорилтыг хэрэгжүүлэх, нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд малын тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, бэлчээр ашиглалтыг сайжруулах ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар юм.

“Бэлчээрийн менежмент төслийн нэгж”-ОНӨТҮГ-ын өдөр тутмын үйл ажиллагааг дарга удирдана. Даргыг Нийслэлийн Засаг даргын Экологи, ногоон хөгжлийн асуудал хариуцсан орлогчийн саналыг үндэслэн Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч томилж, чөлөөлнө.

Байгууллагын бүтэц орон тоо батлагдсан байдал

Д/д	Нийслэлийн Засаг даргын 2016 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн А/493 тоот захирамжаар Бэлчээрийн менежмент төслийн нэгж – ОНӨТҮГ-ын анхны бүтэц орон тоог баталсан	Д/д	Нийслэлийн Засаг даргын 2017 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн А/282 тоот захирамжаар Бэлчээрийн менежмент төслийн нэгж – ОНӨТҮГ-ын бүтэц орон тоог шинэчлэн баталсан
1	Газрын дарга	1	Газрын дарга
2	Төслийн менежер, орчуулагч	2	Төслийн менежер
3	Нягтлан бодогч	3	Нягтлан бодогч
4	Агрономч	4	Агрономч
5	Мэргэжилтэн туслах	5	Хүний нөөц, бичиг хэргийн мэргэжилтэн
6	Сургагч багш оператор	6	Механик инженер
7	Нярав, талбайн зохион байгуулагч	7	Нярав
8	Тоног төхөөрөмжийн оператор	8	Тоног төхөөрөмжийн оператор
9	Манаач, туслах малчин	9	Фермер
10	Жолооч	10	Манаач

Холбогдогч талуудыг тодорхойлох


Холбогдогч талуудыг тодорхойлохдоо “Бэлчээрийн менежмент төслийн нэгж” ОНӨТҮГ-аас бусад байгууллагуудтай харилцах эрх хэмжээг үндэслэсэн болно. Үүнийг ерөнхий байдлаар авч үзвэл Газрын дарга:

1. Дээшээ чиглэлд дээд шатны байгууллага, албан тушаалтнаас гаргасан бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, ажлынхаа үр дүнг тайлагнах, үйл ажиллагаагаа уялдуулан зохицуулах, санал, шийдвэр боловсруулж хүргүүлэх, зөвлөгөө дэмжлэг авах
2. Хэвтээ чиглэлд үйл ажиллагаагаа уялдуулан зохицуулах, хамтран ажиллах, саналаа уламжлах, мэргэжил арга зүйн дэмжлэг авах

3. Доош чиглэлд нэгдсэн удирдлага зохицуулалтаар хангах, үүрэг даалгаврын хэрэгжилтэд хяналт тавих,

“Бэлчээрийн менежмент төслийн нэгж” ОНӨТҮГ-ын үйл ажиллагаанд холбогдогч талууд

Зураг 1



БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХОЛБОГДОГЧ ТАЛУУД

Холбогдогч талууд	Мэдээлэх	Зөвлөх, эргэх холбоогоор хангах	Хамтран ажиллах	Шийдвэр гаргах
Яам				+
ЗГ-ын агентлаг				+
Төр засгийн удирдах дээд байгууллага				+
НИТХ				+
НЗДТГ		+		+
Улаанбаатар хотын захирагчийн ажлын алба		+		+
Нийслэлийн Засаг даргын дэргэдэх агентлаг, харъяа байгууллагууд		+	+	+
Дүүргийн засаг дарга		+	+	+
Хэвлэл мэдээллийн байгууллага	+		+	
Олон улсын байгууллага	+		+	
Сургалт, судалгааны байгууллага	+		+	
Их дээд сургууль, Эрдэм шинжилгээний хүрээлэн	+		+	
Иргэд, ААН	+	+	+	


**ТӨСЛИЙН ХҮРЭЭНД БАЙГУУЛАГДСАН ЗАГВАР АЖ АХУЙН
ФЕРМ, СУРГАЛТЫН ТӨВ**

Төслийн хүрээнд Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн Нарийны хөндийн “Шар хоолойн ам” –ны 500 га газрыг ОРОН НУТГИЙН ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭНД авч 150 га туршилтын талбайг хашиж, сургалтын танхим болон 90 үхрийн жишиг аж ахуйг байгуулсан.

Аж ахуйн талбай



Туршилтын 150 га хашаалсан талбай



“NATRO” – олон наст ургамлын үрийн холимог нь БНАУ-ын баталгаат итгэмжлэгдсэн шинжээч, доцент доктор Карл Букрабер болон бусад эрдэмтэдийн 25 жилийн турш Австри улсад хуурай газар тариалахад тохиромжтой үрийн зөв хольцыг гаргаж авахаар ажилласан туршилтын үр дүнд бий болсон, уулархаг бүсэд зориулагдсан учир монголын тал болон бэлчээрт тариалахад тохиромжтой. Энэхүү “Натро” хэмээх 2 төрөл 8 зүйл 21 сортын үрийн холимогос бүрдсэн олон настын үрийн холимгийг туршилтын 150 га-аас нийт 88 га-д тариалж, ургуулан ургац хураан авч, вакуумжуулан боож бэлтгэн, шинэ төрлийн ногоон тэжээл гарган авсан.

БНАУ-ын “NATRO” үрийн холимгийн бүтэц

№	Төрөл	Зүйлийн нэр	Зүйлийн латин- <u>англи</u> нэршил	Холимог үрэнд орж буй тухайн зүйл ургамлын таригдах сортын нэр (Нийт-21 сорт)	Холимогт зүйл тус бүрийн эзлэх хэмжээ, %
1	Буурцагтан	Мөлхөө хошоонгор	Trifolium Repens L. <i>/Weibklee klondike/</i>	1. Klondike	10
2	Буурцагтан	Цаграс	Medicago <i>/Luzerne Derby/</i>	1. Franken Neu 2. Luzelle	10
3	Үетэн		Dactylis Glomerata <i>/Knaulgras/</i>	1. Tandem	15
4	Үетэн	Олон наст Англи райграс	Lolium Perene <i>/Englisches Ryegras/</i>	1. Barnauta, 2. Guru, 3. Lvana, 4. Litempo, 5. Montando, 6. Tivoli, 7. Trani, 8. Rayrass, 9. WenterRayress	15
5	Үетэн	Нугын биелэг өвс	Poa Pratensis L <i>/Wiesenrispe/</i>	1. Balin, 2. Compact, 3. Lato	10
6	Үетэн	Нугын дурваалиг	Phleum pratense <i>/Timothe/</i>	1. Tiller	15
7	Үетэн	Улаан ботууль	Festuca Rubra L. <i>/Rotschwingel/</i>	1. Echo, 2. Gondolin 3. Light	15
8	Үетэн	Гөлгөр овъёос	Arrhenatherumelatius <i>/Glatthafer/</i>	1. Arone	10

Шинэ төрлийн ногоон тэжээл бэлтгэсэн байдал



Бэлчээрийн талхагдлыг бууруулах зорилгоор тариалалт хийх, ногоон тэжээл хураан авах, вакумжуулан боох зориулалт бүхий бүх техник, бага, дунд оврын тоног төхөөрөмжүүд авч туршилт тохируулгын ажлыг амжилттай хийж байгууллагын үйл ажиллагаанд ашиглаж байна. Үүнд:

1. **New Holland TD5.110** загварын 110 морины хүчтэй трактор - 2 ш
2. **Zena 28** маркийн Эрдэс бордоо цацагч машин-1 ш, 2 холбогч /цацах хэсгийн өргөн 28-36 м/
3. **Merlini M60/40-65** маркийн бууц цацагч - 1ш, шингэн шивх цацагч – 1 ш
4. **GUTTLER** маркийн өвс, тэжээлийн таримлыг тариалах зориулалттай үрлэгч, 110 морины хүчтэй тракторт зориулагдсан /ажлын өргөн 3 м/ -1ш
5. **Дебора** маркийн дискэн хадуур /авах өргөн 3.8 м/ - 1ш
6. Өвс эргүүлэн сэврээгч /авцын өргөн 5.2м/1ш
7. **Giraset T.Trolley** маркийн тармуур /авцын өргөн 3.8м/ - 1ш
8. **Маскио Гаспардо** маркийн өвс хадланг пресслэгч машин /13 ш хутга бүхий механизмтай/
9. **Фаскуаторе 1600** маркийн пресслэсэн өвс ороон боогч Өвс ачих, буулгах сэрээ
10. Хөргөлтийн систем бүхий иж бүрэн автомат саалтуур/саалтуур, сүү хөргөх танк/ 1ш
11. Өтөг бууц хадгалах сав 1ш

№	Нэр төрөл	Марк	Үйлдвэрлэсэн улс байгууллага	Тоо хэмжээ
1	Роторт сийрүүлэгч	1GN-250	БНХАУ Yuchegn yijia machinery Co.,Ltd	1 ш
2	Хөрс сийрүүлэгч хүнд диск	1BZ-3.4	БНХАУ Yuchegn yijia machinery Co.,Ltd	1 ш
3	Анжис	1L-420	БНХАУ Yuchegn yijia machinery Co.,Ltd	1 ш
4	Төмс үрлэгч	2 CM-4	БНХАУ Yuchegn yijia machinery Co.,Ltd	1 ш
5	Төмс хураагч, өөрөө ачигч	4UQL-160	БНХАУ Yuchegn yijia machinery Co.,Ltd	1 ш
6	Дамартай усалгааны машин	JP75/300	БНХАУ Henan Zhongqi Farm Machinery Mechnology Co.,Ltd	1 ш
7	Нарийн ногооны үрлэгч	2CV-14	БНХАУ Yuchegn yijia machinery Co.,Ltd	1 ш
8	Хор цацагч	3WPQ	БНХАУ Fujin Lixing Plant Protection Machinery Co.,Ltd	1 ш
9	Төмсний КОН /манагч/	3QL-5	БНХАУ Yuchegn yijia machinery Co.,Ltd	1 ш
10	Крантай ачааны авто машин	Hubei Dali DLQ4020ST	БНХАУ Hubei Dali Special Automobile Manufacturing Co., Ltd	1 ш

Герман улсад үйлдвэрлэсэн Гуттлэр үрлэгчийг ашиглан бэлчээрийн талбайг хагалахгүйгээр унаган төрхийг хадгалж, “Натро” олон наст ургамлын үрийн холимогоор үрлэгээ хийх шинэ технологийг Монголд анх удаа амжилттай туршиж, нэвтрүүлсний үр дүнд бэлчээрийн талхагдлыг бууруулж, цөлжилтийг зогсоох боломж бүрдсэн.

“Натро” олон наст таримлын холимог үрээр Гуттлэр үрлэгчээр тариалалт хийж байгаа нь



Туршилтын 150 га талбайн дотор болон гадна талаас 2018 оны 4 дүгээр сард авсан хөрсний 6 дундаж дээжинд ХААИС-ийн Агроэкологийн сургуулийн Хөрс агрохимийн лабораторит шинжилгээ хийлгэсэн.

Хөрсний агрохимийн шинжилгээний дүн

№	Дээжний нэр, дээж авсан гүн		pH	Давс, %	Ялзмаг, %	CO ₂ , %	Солилцох сууриуд, мг-экв/100 гр		Шим тэжээлийн элементүүд, мг/100 гр		
							Ca	Mg	NO ₃	P ₂ O ₅	K ₂ O
1	Бордоогүй	0-10 см	6.2	0.06	2.76	-	20	5	1.65	1.6	34
2		10-30 см	6.3	0.05	2.57	-	21	5	0.8	1.8	18
3	2016 онд БНХАУ-ын 6 зүйл олон наст ургамлын холимог үр тарьж, 2017 онд NPK комплекс бордоогоор бордсон	0-10 см	6.2	0.07	3.54	-	18	3	2.46	1.7	38
4		10-30 см	6.4	0.06	1.91	-	18	6	2.06	1.5	18
5	2017 онд БНХАУ-ын 6 зүйл олон наст ургамлын холимог үр тарьж, 2017 онд NPK комплекс бордоогоор бордсон	0-10 см	6.3	0.08	3.99	-	20	4	3.19	2	54
6		10-30 см	6.4	0.09	3.29	-	21	3	4.26	1.5	32


Туршилтын 150 га талбайн хөрсний 0-10 см-ийн гүн дэх ялзмагийн агууламж 3.99 % хүртэл нэмэгдсэн. Үр дүнг доорх графикаар үзүүлэв.



Ногоон тэжээл өгсөнөөр үнээний сүүний гарц нэмэгдсэн байдал

№	Сар	Өдөр	Х.Нэгж	Цагаан үнээ	Нэмэгдсэн байдал	Хар халзан үнээ /18571/	Нэмэгдсэн байдал	Бор алаг үнээ /018579/	Нэмэгдсэн байдал
				Тоо		Тоо		Тоо	
Эхний саам				1420		1580		1430	
1	1	1	гр	1420	0	1580	0	1430	0
2	1	2	гр	1430	10	1595	15	1435	5
3	1	3	гр	1430	10	1600	20	1450	15
4	1	4	гр	1480	60	1620	40	1480	50
5	1	5	гр	1490	70	1680	100	1510	70
6	1	6	гр	1495	75	1690	110	1560	130
7	1	7	гр	1500	80	1700	120	1600	170
8	1	8							

№	Хяналтын үзүүлэлт	Эхний саамны хэмжээ, гр	Эцсийн саамны хэмжээ, гр	Саамны нэмэгдсэн хэмжээ, гр	Нэмэгдсэн хувь
1	Цагаан үнээ	1420	2300	880	61%
2	Хар халзан үнээ /18571/	1580	2230	650	41%
3	Бор алаг үнээ /018579/	1430	2310	880	61%




СХД, 21-р хороо, Нарийний хөндийн Шар хоолойн аманд байршилтай 150 га талбайгаас авсан ургамлын дээжний шинжилгээг 2018 онд МААЭШХ-ийн тэжээлийн үнэлгээний лабораторт хийлгэсэн.

Шинжилгээний хариуны тайлбар

№	Үзүүлэлт	Шинжилгээний арга	Дээж авсан огноо	Дээж авсан талбайн хэмжээ м ²	Шинжилгээ хийсэн дээжний код, нэр, үр дүн				
					1	2	3	4	5
					2017 онд Аж ахуйн хашааны гол хэсэгт Австри үрээр усалгаатай үрийн норм ахиу тарьсан талбайгаас авсан ургамлын дээж	2018 онд Австри үрээр тарьсан 150 га талбайн гол хаалганы ойролцоо талбайгаас авсан ургамлын дээж	2017 онд аж ахуйн хашаан доторх 100 м ² туршлагын талбайн Австри үрээр NPK-ийн бордоогоор бордсон талбайгаас авсан ургамлын дээж	150 га талбайн дээд хаалганы дотор талд тариалалт хийгдээгүй, NPK-ийн бордоогоор бордсон талбайгаас авсан ургамлын дээж	2018 онд Австри үрээр тарьсан 150 га талбайн урд үзүүрийн талбайгаас авсан ургамлын дээж /сайн ургасан шивээ ихтэй хэсэг/
1	Чийг, %	MNS 6548:2015	8/31/2018	1	5.8	6.0	6.1	7.2	5.4
2	Нийт уураг, %	MNS 6550:2015	8/31/2018	1	17.3	10.6	18.9	10.6	12.6
3	Нийт эслэг, %	MNS 6551:2015	8/31/2018	1	25.1	28.5	21.4	22.6	24.2
4	Нийт үнс, %	MNS 6548:2015	8/31/2018	1	10.0	6.9	10.2	8.2	8.6
5	Нийт тослог, %	MNS 6548:2015	8/31/2018	1	3.2	3.3	3.5	4.2	3.7

Шинжилгээний хариуны тайлбар





Хавсралт 7

Мал Аж Ахуйн Эрдэм Шинжилгээний Хүрээлэнгийн эрдэмтэн, судлаачидтай хамтран нийт туршилтын талбайн хэмжээнд томоохон судалгааны ажлыг 2021 оны 3 дугаар улиралд хийж гүйцэтгэсэн. Судалгааны ажлын үр дүнгийн тайлангаас харахад туршилтын 150 га талбайн хэмжээнд 1 га-ын биологийн дундаж ургацаар авч үзэхэд ашиглалтаас чөлөөлж бордсон талбай нь ашиглалттай хашааны гадна талбайгаас 8,5 дахин, хашсан талбайгаас 3,6 дахин илүү байсан.

Доорх хүснэгт, графикаар харуулав



Ашиглалтаас чөлөөлж үр нэмэрлэн тариалалт хийж, бордсон талбайн тусгаг бүрхэц нь ашиглалттай бэлчээрээс 34,0 хувиар буюу 1,5 дахин хашсан бэлчээрээс 9,0 хувиар буюу 1,1 дахин их илүү байлаа. Тус талбайн ашиглалтаас 5 жил чөлөөлөхөд 7±2 ширхэг ургамал нэмэгдэж, дунд зэргийн доройтлоос хэвийн бэлчээр болж сэргэсэн нь бордооны нөлөө, үр нэмэрлэж тариалсан нь үр дүнгээ өгсөн байна. Судалгааны талбайг зүйлийн бүрэлдэхүүнээр авч үзэхэд дундажаар ашиглалтаас чөлөөлж бордсон талбайд 25±4 , ашиглалтаас чөлөөлсөн талбайд 17±4, ургамлын тусгаг бүрхэц 94,0 хувь үүнээс хагд нь бүрхэвч 18,0 хувь хоосон халцгай газар 6,0 хувь, ургац 29 ц/га, ургамлын дундаж өндөр 26,6 см үзүүлэлт нь бэлчээрийн талбай сэргэж хэвийн бэлчээрийн төрхт шилжсэн байна.

Судалгааны талбарын ургамлын нэгдсэн үнэлгээгээр

Бичиглэл №	Ашиглалтын хэлбэр	Зүйлийн Тоо ширхэг	Тусгаг Бүрхэц %	Халцгай газар %	Ургац ц/га
1	Ашиглалтаас чөлөөлж, үр нэмэрлэсэн, бордоо цацсан	36	81,5	6,0	33.1
2		30	75,0	7,0	22.4
3		21	74,0	4,0	14.1
4		20	73,5	6,0	19.4
5	Ашиглалтаас чөлөөлсөн	17	60,0	15,0	9.3
6	Хашааны гадна /ашиглалттай бэлчээр/	10	49,0	40,0	3.4

ҮЙЛДВЭРЛЭЛ, МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХ, ҮР АШГИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР

2018-2021 ОНУУДАД ХҮРСЭН ТҮВШИН

Бэлчээрийг нөхөн сэргээхэд зориулагдсан манай орны хөрс цаг уурын нөхцөлд тохирсон Бүгд Найрамдах Австри Улсад үйлдвэрлэсэн, 2 төрлийн 8 зүйл ургамлаас бүрдсэн олон наст тэжээлийн ургамлын “НАТРО” холимог үрээр 2018 оноос хойш нийт туршилтын 150 га талбайн **88** га-д хөрсийг хөндөхгүй шинэ технологиор тариалалтын ажлыг хийж гүйцэтгэсэн. “НАТРО” холимог үрээс эхний хоёр жил 5-6 зүйл ургамал нутагшиж ургасан, 3 дахь жилээс 5 зүйл үетнээс гадна царгас, хошоонгор гэсэн 2 зүйлийн буурцагтан ургамал ургасан.

Дөрвөн жилийн хугацаанд “НАТРО” болон Хятад үр тариалсан 65 га талбайгаас нийт 50600 кг (2021 онд 33500 кг) ургац хураан авч, боож, шинэ төрлийн ногоон тэжээл бэлтгэсэн.

Сүүлийн хоёр жилийн хугацаанд ногоон тэжээл хураан авахад 1 га-ын дундаж ургац 450-550 кг байсан бол 2021 оны байдлаар Натро үрээр бордож тариалалт хийсэн талбайд 2 зүйлийн буурцагтан, 5 зүйлийн үетэн ургамлыг ургуулж, төрөл зүйлийг нэмэгдүүлсний дүнд 1 га-ын дундаж ургацыг 1300 кг-д хүргэсэн. Бусад, талбайн ургацыг 830 кг болгож сайжруулсан.



Тариалт хийгдээгүй
талбай



Тариалалт хийгдээд ургаж
байгаа талбай



Тариалалт хийгдээд ургасан
талбай

Хүний нөөцийн өнөөгийн байдалд ерөнхий байдлаар шинжилгээ хийж үзвэл:

Албан хаагчдын 70 хувь нь улсад 10-аас дээш жил ажиллаж байгаа нь туршлагатай, чадвартай боловсон хүчнээр хүний нөөцөө бүрдүүлсэн байна. Үлдсэн нь 20 хувь нь тухайн байгууллагад 3-аас дээш жил ажиллаж байгаа, 1 албан хаагч 1 жил ажиллаж байгаагаас үзэхэд байгууллагын үйл ажиллагааг амжилттай хөтөлж явуулахын тулд тэднийг сургалтанд хамруулж, мэдлэг, чадварыг нь дээшлүүлэх шаардлагатай болохыг харуулна.



Нийт албан хаагчдын боловсролын байдал, мэргэжлийн зэргийг нь авч үзвэл Мэргэжлийн зөвлөх зэрэгтэй 1, Магистр зэрэгтэй 3, бакалавр зэрэгтэй 4, бүрэн дунд боловсролтой 2, тусгай мэргэжлийн зэрэгтэй 1 хүн байна.

Байгууллагын хэмжээнд жендерийн тэгш байдлын хувьд /2023.01 сарын байдлаар/



ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

Хөтөлбөрийг цаашид амжилттай хэрэгжүүлэхийн тулд дараахь асуудлуудыг шийдвэрлэх шаардлагатай. Үүнд :

- Манай орны нөхцөлд Натро үрийн холимогоос ургасан үрнүүдээс сонгон авч, Монголд нутагших боломжтой үрийн холимгийг мэргэжлийн байгууллагатай хамтран гарган авах ажлыг зохион байгуулах
- Шинэ төрлийн ногоон тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлсний үр дүнд саалийн хугацаанд нэг үнээнээс авах сүүний гарцыг нэмэгдүүлэх, цаашид малын үүлдэр угсааг улам сайжруулах
- Иргэд, ААН-ийн захиалгаар газар тариалангийн үйлчилгээ үзүүлэх замаар орлого бүрдүүлэх,
- Малчдын хоршоо байгуулах ажлыг Нийслэлийн Хүнс, Хөдөө аж ахуйн газартай хамтран зохион байгуулах,
- Ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг төрийн болон ТББ, олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх, туршлага судлах, санхүүжилтийн шинэ эх үүсвэрүүдийг хайх,
- Хөрсний чанарыг сайжруулах зорилгоор органик болон компост бордоогоор бэлчээрийн талбайг бордох, эдгээр бордооны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх,
- Хөрсний чийгийн хангамж сайн байх үед хугацааг тооцож тариалалт хийх, чийгийг аль болох удаан барих бордоо, бодисыг судлах,
- Жил бүрийн төсөвт “Натро” болон бусад нэг ба олон наст тэжээлийн ургамлын үрийг болон NPK бордоо худалдан авах хөрөнгийн эх үүсвэрийг тусгаж, шийдвэрлүүлж байх,
- Монгол орны бэлчээрийн нөхцөлд нутагшсан олон наст ургамлын үр болон хошуу будаа, арвай, вандуй, судан өвс, тэжээлийн нэг наст ургамлыг тариалж, хураан авах ногоон тэжээлийн хэмжээг нэмэгдүүлэх.

